



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн хяналтын хуудас
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1.Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх шинээр боловсруулсан 1.36 кодтой “Ургамал хамгаалах бодис, бордоо, бэлдмэл үйлдвэрлэлийг шалгах”, 1.37 кодтой “Ургамал хамгаалах бодис, бордоо, бэлдмэл ханган нийлүүлэх, худалдаалах үйл үйл ажиллагааг шалгах”, 1.38 кодтой “Ургамал хамгааллын арга хэмжээг шалгах”, 1.39 кодтой “Үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх үйл ажиллагааг шалгах” хяналтын хуудсуудыг нэгдүгээр хавсралтаар, шинэчлэн боловсруулсан 1.1, 1.18, 1.24, 1.25, 1.28 кодтой хяналтын хуудсуудыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан хяналтын хуудсуудыг хяналт шалгалтад хэрэглэх, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын газар, Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар, аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3.Хяналтын хуудас шинэчлэн баталсантай холбогдуулан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2015 оны “Хяналтын хуудас батлах тухай” 540 дүгээр тушаалаар батлагдсан 1.1, 1.28, 2015 оны “Хяналтын хуудас батлах тухай” 90 дүгээр тушаалаар батлагдсан 1.18, 1.24, 1.25 кодтой хяналтын хуудсуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Хяналтын хуудасны ашиглалт, хяналт шалгалтын явц, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, дүн шинжилгээ хийсэн байдалд хяналт тавьж ажиллахыг Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газрын дарга /М.Наранбат/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ЦАГААНХҮҮ

09 336

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын
2017 оны 02 дугаар сарын 15 ны өдрийн
А/43 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ШИНЭЭР БОЛОВСРУУЛСАН ХЯНАЛТЫН ХУУДАСНЫ НЭР, КОД

№	Хяналтын хуудасны код	Хяналтын хуудасны нэр	Хяналтын хуудасны тоо
1	1.36	Ургамал хамгаалах бодис, бордоо, бэлдмэл үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
2	1.37	Ургамал хамгаалах бодис, бордоо, бэлдмэл ханган нийлүүлэх, худалдаалах үйл үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
3	1.38	Ургамал хамгааллын арга хэмжээг шалгах хяналтын хуудас	1
4	1.39	Үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
Нийт хяналтын хуудасны тоо			4

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын
2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн
А/43 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ХЯНАЛТЫН ХУУДАСНЫ НЭР, КОД

№	Хяналтын хуудасны код	Хяналтын хуудасны нэр	Хяналтын хуудасны тоо
1	1.1	Мах эхлэн боловсруулах үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
2	1.18	Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, савлалт, тээвэрлэлтийг шалгах хяналтын хуудас	1
3	1.24	Үрийн болон хүнсний буудай хүлээн авах, хадгалах, борлуулах үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
4	1.25	Таримал ургамлын үр үйлдвэрлэдэг, бусдад нийлүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
5	1.28	Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
Нийт хяналтын хуудасны тоо			5